

ХЭРЛЭН СУМ



АРДЧИЛСАН НАМЫН ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ХОРООНЫ 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020.06.23





АРДЧИЛСАН НАМЫН ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ХОРООНЫ 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР .

НЭГ. ХӨГЖЛИЙГ БҮТЭЭХ ХЭРЛЭНЧҮҮД /Хувь хүний хөгжил, эрх чөлөө/

Хэрлэн сумын иргэн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй эрүүл амьдарлын хэв маягийг хэвшил болгосон, Монгол эх орныхоо байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан өв тэгш хүмүүжлээр төлөвшүүлэн хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ.

- 1.1 Хан Хэнтийнхээ иргэн бүрийг үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг төлөвшилтэй болгоход зориулан "Оюунлаг Хэнтийчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2 Хэрлэн суманд "Зөв Монгол хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3 "Хэрлэнгийн ирээдүй -Багшийн хөгжил" хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.4 Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар сургууль, цэцэрлэгийн удирдах албан тушаалтаныг томилох, чөлөөлөхөд сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн "Боловсролын зөвлөл-ийн саналыг харгалзана.
- 1.5 Чингис хотод Хэрлэн I лаборатор сургуулийн 1500 хүүхдийн багтаамж бүхий хичээлийн шинэ байр, бусад цогцолборын өргөтгөлийн хийнэ.
- 1.6 Хэрлэн суманд сургуулийн хүүхдийн дотуур байрыг шинээр барина.
- 1.7 Сумын хэмжээнд шаардлагатай газарт цэцэрлэгийн барилга, зарим цэцэрлэгт их засвар хийнэ.
- 1.8 Эмчийн чадавхи, эмчилгээний үр дүнг үнэлэх цахим систем ажиллуулж, сайн эмчийг сонгож үйлчлүүлэх өрсөлдөөнд суурилсан тусламж үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 1.9 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, хэвшүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэн "Эрүүл мэндийг дэмжигч" сум болно.
- 1.10 "Архигүй Хэрлэн-2" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.11 Сумын хэмжээнд гэр бүлийн гишүүн бүрт ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, мэдлэг үр чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 1.12 Чингис хотын иргэдээ зээлийн хөнгөлөлтэй нөхцөлөөр хувийн орон сууцтай болгох тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж, ипотекийн 8 хувийн зээлийг үргэлжлүүлэн олгоно.
- 1.13 Залуу гэр бүл, ахмад, өндөр настан, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн өрхийг түрээсийн орон сууцаар хангах ажлыг эхлүүлнэ.
- 1.14 Байгальд ээлтэй түүхэн аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх "Алтан аргамж" хөтөлбөрт хамрагдаж олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.



- 1.15 Чингис хотод олон улсын 4-С ангилал зэрэглэл бүхий "Өндөрхаан" нисэх буудлыг аялал жуулчлалын бусад байгууламжийн хамт ашиглалтад оруулна.
- 1.16 Аймгийн төвд , орон нутаг судлах, байгалийн түүх, түүхэн өв соёлын музейн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.

ХОЁР. ӨСӨЛТИЙГ БҮТЭЭГЧ ХЭРЛЭНЧҮҮД / Хүртээмжтэй эдийн засаг/

"Ажлын байр- Аймгийн хөгжил" чиглэлийг эрхэмлэн хөдөлмөрлөж, эдийн засгийн өсөлтийг өрх бүрээрээ хүртсэн бүтээгч Хэнтийчүүд ,бусдад жишиг байх үзэл баримтлалыг мөрдөн ажиллана.

- 2.1 "Ажлын байр-Сумын хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлж байнгын болон түр ажлын байраар 1000 хүнийг хангана./сумын ахуйн үйлчилгээний төвүүд, төмс хүнсний ногоо боловсруулах жижиг үйлдвэрүүд, өвлийн хүлэмж/
- 2.2 Чингис хотын гадаад харилцааны бодлогодоо эдийн засгийн түншлэл, худалдааны болон нийгмийн олон талт хэлэлцээрүүдийг байгуулан хэрэгжүүлнэ.
- 2.3 Технологийн дэвшлийг ашиглах замаар авилгыг мэдээлэх, илрүүлэх боломжийг бүрдүүлж бизнест учирдаг авилгын дарамтыг арилгана.
- 2.4 Чингис хотод Засгийн газрын дэмжлэг хөрөнгө оруулалтаар дулааны станцыг барьж, боломжит газруудад хэрэглээний халуун усны хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр шийдвэрлэнэ .
- 2.5 Хэрлэн сумандaa өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төмс хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлж хүлэмж , агуулах, зоориудын барьж байгуулна.
- 2.6 Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож татвар хураамжийг нэмэхгүйгээр жигд үйлчлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.7 Иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр ажиллах нөхцөлийг журамлаж гарал үүслийн гэрчилгээ олгох замаар дундын зуучлагч, ченжүүдийн хараанд орохос урьдчилан сэргийлнэ.
- 2.8 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлнэ.
- 2.9 Аймгаас хэрэгжүүлэх "1000 өрх орон сууц" хөтөлбөрт давуу эрхээр хамрагдана. / хаус хороолол, түрээсийн гэх мэт/
- 2.10 Соёлын төвийг шинээр барьж ашиглалтад оруулна.

ГУРАВ: НУТАГТАА ЭЗЭН ХЭРЛЭНЧҮҮД /Эзэн Монгол/

Бие даасан эдийн засагтай, эх орныхоо баялагаас хувь хүртсэн эдийн засгийн хувьд бие даасан, зөв засаглалд тэгш оролцож, түүх өв соёлоо эрэхмлэн дээдэлж нутагтадаа эзэн хувь хүнийг төлөвшүүлнэ.

- 3.1 Чингис хотын дахин төлөвлөлтийг олон нийтийн оролцоотойгоор хийж мөрдөн ажиллана./гэр хороолол болон амины орон сууцуудыг инженерийн шугам сүлжээнд шат дараатай холбоно.



1714429
046 907

3.2 Хэрлэн сум, Чингис хотын хэмжээнд газар олгосон нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж иргэд, аж ахуй нэгжүүдэд газар олголтыг ил тод болгож цахимжуулна ./Хууль, журамд үл нийцүүлэн олгосон газрын эрхийг цуцлана.

3.3 Хэрлэн сум Чингис хотдоо "Хашаандаа сайхан амьдарья", "Жорлонгоо өөрчилье" төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

3.4 Сумын хэмжээнд мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай /орчин үеийн шинэ технологи, инновацийд суурilan хөгжүүлж малчдыг малчин бизнесмэн болгох замаар тогтвортой орлоготой, хүчтэй дундаж давхаргыг бий болгох "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.5 Экспортод чиглэсэн өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.

3.6 Малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах гэрийн сургалтын тогтолцоонд хамрагдана.

3.7 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээрийн зохистой менежментийг боловсруулан баталж хэрэгжүүлж эхэнэ.

3.8 Сумынхаа хилийн цэсийг тодотгон баталгаажуулах, хаягжуулах ажлыг хэрэгжүүлнэ.

3.9 Чингис хотын хатуу хучилттай зам болон гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.

3.10 Max махан бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулан малыг эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.

ДӨРӨВ. ХУУЛИЙГ ДЭЭДЛЭГЧ ХЭРЛЭНЧҮҮД /Хуультай Монгол//

Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж хөгжлийг дэмжин, авлигаас ангид ажиллах чадавхитай засаг, хүн бүр ажил, албан тушаалаасаа үл хамаарч хуулийн өмнө хариуцлага хүлээдэг шударга шүүхийн тогтолцоо, мэргэжлийн хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлэх цогц шинэчлэл хийнэ.

4.1 Хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүргийг иргэдийг дарамтлах айлгах бус аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэхэд чиглүүлж, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлнэ.

4.2 Авилга, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, ялгамжгүй, шударга, хүртээмжтэй хүнд сурталгүй хүргэнэ.

4.3 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, аюулгүй амар тайван амьдрах баталгааг хангахад анхааран ажиллана.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН ХЭРЛЭНЧҮҮД / Аюулгүй, амгалан Монгол/

Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгын зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдарлын чанарыг сайжруулна.



- 5.1 Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялагийн зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргээх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдралын чанарыг сайжруулсан байгальд ээлтэй "Ногоон сум" болгоно.
- 5.2 Чингис хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн иргэн бүр нэг мод төсөл хэрэгжүүлсэнээр ногоон хот болох нөхцөл бүрдүүлж иргэдийн мод үржүүлгийн ажлыг онцгойлон дэмжинэ.
- 5.3 Аймгийн төвийн утааг бууруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүч, шинэ техник технологийг ашиглан дулаан, цахилгаан нийлүүлэх иргэд аж ахуй нэгжийг бодлогоор дэмжиж "Утаагүй хот" төслийг хэрэгжүүлнэ.
- 5.4 Сумын хэмжээнд байгаа гол, булаг, шанд, нуур, цөөрмийг хамгаалалтад авч байгалийн тэнцвэрт байдлыг хангана.
- 5.5 "Хутаг" уул түүний орчны хамгаалалтыг сайжруулж, шинээр тарвага үржүүлэх болон ан амьтдын тоо толгойг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлнэ.
- 5.6 Хэрлэн голын сав газрыг хамгаалах мененжментийн төлөвлөгөөний дагуу хөв цөөрөм байгуулж усны нөөцийг хуримтлуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 5.7 Чингис хотын ойролцоо сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрийг төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.
- 5.8 Хэрлэн сумын хүн амыг цэвэр усны баталгаат эх үүсвэрээр хангах зорилгоор тусгай технологи бүхий 2-оос доошгүй гүний худаг гаргана.
- 5.9 I, II, V багуудыг дулааны шугам шинээр татан зарим газарт смарт худгийг шинээр барина.

МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ БОЛОВСРУУЛСАН:

АРДЧИЛСАН НАМЫН ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.АМГАЛАНБААТАР

ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН
ХОРОО

8488916 XHT1204

2020 оны 06 сарын 23 өдөр